



**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ**

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 он 04 сар 18 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

**Тэтгэлгийн журмыг шинэчлэн
батлах тухай**

Тус сургуулийн дотоод журам, холбогдох алба, ерөнхий захирлын санал, захиргааны зөвлөлийн 16 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус сургуулийн “Оюутны тэтгэлгийн журам”-ын холбогдох заалтуудыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.ОУУБИС-ийн Ерөнхий захирлын 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/82-р тушаалын хавсралт “Оюутны тэтгэлгийн журам”-д өөрчлөлт оруулсугай.

3.Энэхүү журмыг 2022-2023 оны хичээлийн жилийн 2-р улирлаас мөрдсүгэй.

4.Дээрх журамтай холбоотой хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэтгэлгийн зөвлөл (Ким Жэ Сон), Санхүүгийн хэлтэс (Э.Чулуунцэцэг)-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



КАН ЮУ ЁЛЬ



Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн бакалаврын зэргээр суралцаж буй оюутанд олгох тэтгэлгийн журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 ОУУБИС-д бакалаврын зэрэг горилон суралцаж буй оюутнуудын сургалтын чанарыг сайжруулах, нийгмийн халамж, үйлчилгээг дэмжих, амьдралын нөхцөл байдалд туслах болон тэтгэлэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 ОУУБИС-ийн оюутанд тэтгэлэг олгох асуудлыг зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ. Тэтгэлгийн зөвлөлд Сургалтын албаны дарга, Оюутны албаны дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд байна.

1.3 Тэтгэлгийн мөнгөн хуримтлалыг бүрдүүлэх ажлыг Оюутны алба, Санхүүгийн хэлтэс хариуцан ажиллана.

1.4 Тэтгэлэгт хамрагдах оюутныг бүртгэх, сонгон шалгаруулах, батламж гардуулах үйл ажиллагааг Оюутны алба хариуцан зохион байгуулна.

1.5 Тэтгэлгийн журам боловсруулах, батлах, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хуваарилах, тэтгэлэг олгох, тэтгэлгийн төрөлд нэмэлт санал оруулах, шинэчлэн боловсруулах ажлыг Оюутны алба гүйцэтгэн тэтгэлгийн зөвлөлд танилцуулж, ерөнхий захирлын тушаалаар батлуулна.

Хоёр. Тэтгэлгийн төрөл, тавигдах шаардлага

2.1 ОУУБИС-ийн бакалаврын зэргээр суралцаж буй оюутанд олгох тэтгэлэг нь төлөөлөн удирдах зөвлөлийн даргын нэрэмжит, ерөнхий захирлын нэрэмжит, голч дүн байгууллага, хувь хүний нэрэмжит, спорт, урлаг, эрдэм шинжилгээ, судлаач оюутан, халамж, нийгмийн үйлчилгээ, цагийн ажлын оюутан, оюутны зөвлөл, шинэ элсэгчдэд, багш, ажилчдын хүүхдэд олгох тэтгэлэг гэсэн төрлүүдтэй байна.

2.1.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын нэрэмжит тэтгэлгийг салбар тус бүрийн хэмжээнд сурлагаараа тэргүүлсэн, тухайн улиралд 12 багц цаг (кредит)-аас дээш хичээл судалсан, тухайн салбараас хамгийн өндөр голч дүнтэй нэг оюутанд улирлын сургалтын төлбөрийн 50-100 хувийн тэтгэлгийг олгоно.

2.1.2 Ерөнхий захирлын нэрэмжит тэтгэлгийг тэнхим тус бүрийн хэмжээнд сурлагаараа тэргүүлсэн, тухайн улиралд 12 багц цагаас дээш хичээл судалсан, тухайн тэнхимээс хамгийн өндөр голч дүнтэй нэг оюутанд улирлын сургалтын төлбөрийн 40-100 хувийн тэтгэлгийг олгоно.

2.1.3 Байгууллага, хувь хүний нэрэмжит тэтгэлгийг тухайн байгууллага, хувь хүний санал, шаардлага, болзлыг хангасан оюутанд олгоно.

2.1.4 ОУУБИС-ийн нэрийн өмнөөс урлаг, спорт, эрдэм шинжилгээний бүтээлээр хот, улс, олон улсын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож эхний гурван байр эзэлсэн, тухайн улиралд 12 багц цагаас дээш хичээл судалсан, **2.0**-ээс дээш голч дүнтэй оюутанд улирлын сургалтын төлбөрийн 30-100 хувийн тэтгэлгийг олгоно.

2.1.5 Нийгмийн үйлчилгээний тэтгэлгийг тухайн улиралд 60 цагаас дээш ажилласан оюутанд улирлын сургалтын төлбөрийн 10-100 хувийн тэтгэлгийг олгоно. Нэг цагийг нэг оноогоор тооцох бөгөөд хичээлийн жилийн улирал бүрийн төгсгөлд дүгнэгдэнэ.

2.1.6 Халамжийн тэтгэлгийг тухайн улиралд 12 багц цагаас дээш хичээл судалсан, **3.0**-ээс дээш голч дүнтэй, сургалтын төлбөрөө төлөх боломжгүй, амьдралын түвшин доогуур, гэр бүлийн гишүүд нь хөдөлмөр эрхлэх чадваргүй, өөрийн эрүүл мэндийн байдал, ам бүл олуулаа, бүтэн, хагас өнчин, орон нутгийн оюутан зэргийг харгалзан тэнхимийн багш нарын хурлын шийдвэрээр тухайн оюутанд улирлын сургалтын төлбөрийн 30-100 хувийн тэтгэлгийг олгоно. Түүнчлэн гэнэтийн болон зам тээврийн осол, байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн байдлыг харгалзан үзэж тэтгэлэг олгож болно.

2.1.7 Оюутны зөвлөлийн гишүүнд олгох тэтгэлгийг оюутны зөвлөлийн гишүүдээс өөрийн хариуцсан тэнхим, сургуулийн хэмжээний үйл ажиллагаанд идэвх чармайлт гарган ажилласан тухайн улиралд 12 багц цагаас дээш хичээл судалсан, **2.5**-аас дээш голч дүнтэй оюутанд улирлын сургалтын төлбөрийн 30-100 хувийн тэтгэлгийг олгоно.

2.1.8 Шинэ элсэгчдэд олгох тэтгэлгийг тухайн хичээлийн жилийн элсэлтийн журмын дагуу тэтгэлэг олгоно.

2.1.9 Тус сургууль, салбар бүрэн дунд сургууль, цэцэрлэгт ажиллаж буй багш, ажилтан, ажилчдын хүүхэд суралцах тохиолдолд багш, ажилтан, ажилчдын ажилласан жилээс харгалзан 0-10 жил 40 хувь, 10-аас дээш 50 хувиар тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

2.1.10 Цагийн ажлын оюутны тэтгэлэг нь бүрэлдэхүүн сургууль, тэнхим, алба, хэлтэс, төвүүдэд ажилласан тохиолдолд 10-100 хувийн тэтгэлэг олгоно.

2.1.11 Судлаач оюутны тэтгэлгийг Бүрэлдэхүүн сургуулиудын захирлын саналын дагуу улиралд 1 оюутан ажиллана. Оюутан 60 цагаас дээш цаг ажилласан, судалгааны ажил хийж дүгнэн, илтгэл тавин дараагийн улирлын сургалтын төлбөрийн 30 хувийн тэтгэлэг олгоно.

Гурав. Бусад

3.1 Байгууллага, хувь хүний нэрэмжит тэтгэлгээс бусад сургуулиас олгож буй тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

3.2 Боловсролын зээлийн сангаас буцалтгүй тусламж нөхцөлөөр санхүүжигдэн суралцагчийн хувьд оюутны өөрөөс төлөх төлбөрийг хөнгөлнө.

3.3 Тэтгэлэгт бүртгэх хугацаа улирал бүрийн төгсгөл буюу хичээл хаагдсаны дараа хоёр долоо хоногийн дотор явагдана.

3.4 Тэтгэлэгт бүртгүүлэхдээ дараах зүйлсийг бэлдэнэ. Үүнд:

- Дүнгийн тодорхойлолт /Сургалтын албанаас авна/
- Тэтгэлгийн анкет бөглөх /Оюутны албанаас авна/
- Зөвлөх багшийн тодорхойлолт /Анкетыг Оюутны албанаас авна/
- Тэнхимийн сонгон шалгаруулалтын хурлын протокол

3.5 Тэтгэлэг олгохоос татгалзах, хүчингүйд тооцох, суралцсан хугацааны сургалтын төлбөрийг эргэн төлүүлэхэд дараах зүйлийг баримтална. Үүнд:

3.5.1 Улирлын болон жилийн чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг олгохоос татгалзаж хүчингүйд тооцно.

3.5.2 Сургуулиас гарах, өөр сургууль руу шилжих, гэмт хэрэгт холбогдох, сургуулиас хөөгдөх, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд суралцсан хугацаанд олгосон тэтгэлгийг эргэн төлүүлнэ.

3.6 Тэтгэлэгт хамрагдах хугацаа нь хичээлийн жилийн **3-аас 8-р** улирал байна.

3.7 Тэтгэлэгт хамрагдсан оюутны сургалтын төлбөрийн илүүдлийг дараа жилийн сургалтын төлбөрт шилжүүлэн тооцох бөгөөд 4-р курст буцаан олгоно.